



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай-Улиастайн эрчим хүчний систем төрийн өмчит хувьцаат компанийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/01/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд, Б.Цэцэгмаа, М.Атарцэцэг Аудитор: Б.Батбаатар Утас: 99086371, 99488754, 88984411 Цахим хаяг: govialtai@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.15 № 123

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд багтдаг төрийн өмчийн төлөөллийн болон хараат бус 4 гишүүн өөрчлөгдсөн, гүйцэтгэх захирлын томилгоог 3 удаа хийсэн байна.

Аудитын гол асуудал

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор ажиллагсдын үндсэн цалинг 2023 оны 11 дүгээр сарын 1-нээс 29 хувиар нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн байна. Гэвч 2023 оны 01 дүгээр сарын 1-нээс эрчим хүчний салбарын ажиллагсдын цалингийн доод жишиг нэмэгдсэнтэй холбоотойгоор жишгээс доош цалинждаг албан хаагчдын цалинг 208.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 11 дүгээр сарын 1-нээс бүх ажиллагсдын цалинг 20.0-50.0 хувиар харилцан адилгүй нэмэгдүүлсэн байна.

Мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол шийдвэргүйгээр толгой компанийн гүйцэтгэх захирлуудад 11,055.4 мянган төгрөг, охин компаниудын гүйцэтгэх захирлуудад 6,467.2 мянган төгрөгийн сарын үр дүнгийн урамшууллыг тус тус олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

0702700406

Тайлант онд 8 зорилтын хүрээнд 129 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан бөгөөд гүйцэтгэлийн тайлангийн биелэлтийг хувиар тооцож гаргаагүй бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөл ажлыг үнэлээгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	5,800,211.3	5,420,309.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	97,345,441.3	93,532,008.4
	Нийт хөрөнгийн дүн	103,145,652.6	98,952,317.7
	Нийт өр төлбөрийн дүн	43,691,744.7	43,654,838.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	59,453,907.9	55,297,479.7
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	103,145,652.6	98,952,317.7
	Борлуулалтын орлого	15,466,940.2	19,062,724.7
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	16,112,855.8	19,686,589.7
	Нийт алдагдал	(645,915.6)	(623,865.0)
	Нийт зардал	4,471,561.6	4,883,384.4
	Татвар төлөхийн өмнөх алдагдал	(3,202,255.4)	(4,127,066.0)
	Орлогын татварын зардал	21,018.6	31,403.9
	Татварын дараах алдагдал	(3,223,274.0)	(4,158,469.8)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	62,589,600.84	59,453,907.87
	НББ-ийн бодлогын өөрчлөлт нөлөө, алдааны залруулга	87,580.99	-
	Тайлант оны үр дүн	(3,223,273.95)	(4,158,469.84)
	Өмчид гарсан өөрчлөлт	-	2,041.67
	Эцсийн үлдэгдэл	59,453,907.87	55,297,479.70
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	20,014,617.8	35,572,720.9
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	18,977,268.2	35,766,340.6
	Үйл ажиллагааны ЦМГ	1,037,349.7	(193,619.7)
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	62,317.5	(213,059.6)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	1,099,667.2	(406,679.3)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	25,914.3	2,230,995.7
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,230,995.7	1,824,316.4
Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлийн тайлан			
	Нийт орлого	18,183,602.2	17,797,844.9
	Нийт зардал	22,200,100.0	21,956,313.8
	Нийт алдагдал	(4,016,497.8)	(4,158,468.9)

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар илэрсэн 4,223,688.3 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой: Нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайланд борлуулалтын орлогыг 3,146,027.8 мянган төгрөгөөр, зардлыг 958,665.0. мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд орлогыг 24,986.3 мянган төгрөгөөр, зардлыг 73,548.3 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгийн тайланд 18,576.6 мянган төгрөгийн, авлагыг 1,884.2 мянган төгрөгөөр нийт 4,223,688.3 мянган төгрөгийн залруулга хийсэн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;", Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн заалттай нийцээгүй тул залруулсан.

Залруулагдаагүй нийт 247,697.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 247,697.0 мянган төгрөгийн 43 зөрчил² илэрч 80,872.7 мянган төгрөгийн 10 төлбөрийн акт тогтоож, 109,475.7 мянган төгрөгийн зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 20 албан шаардлага, 57,348.7 мянган төгрөгийн 13 зөвлөмж хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

1. Тайшир-Гуулин УЦС ХХК нь гэрээний дагуу төвлөрсөн түрээсийн орлогын 40.0 хувь буюу 11,592.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай" тогтоолын 2-т "Түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх хэмжээг нийт орлогын 40 хувиар тогтоосугай" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Түрээсийн төлбөрийн орлогыг төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

2. Алтай-Улиастайн Эрчим хүчний систем ТӨХК болон Завхан салбар нь ажилтны амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан 7,643.7 мянган төгрөгийг олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.1-т "Ээлжийн амралтын цалинг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлснөөс тооцож олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/19 дүгээр тушаалын хавсралтын 3 дугаар зүйлийн 3.4-т "Ээлжийн амралтын цалинг тооцохдоо өмнө эдэлсэн ээлжийн амралтаас хойш ажилласан саруудын цалин хөлсний нийлбэрийг, тухайн саруудад ажилласан ажлын өдрийн нийлбэр тоонд хуваан ажлын нэг өдрийн дундаж цалин хөлсийг гаргаж ээлжийн амралтын өдрөөр үржүүлж бодно" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон цалинг төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

3. Толгой болон охин компаниуд нь хамтын гэрээ, хэлэлцээрийн дагуу 11, 12 дугаар сард шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг 1.5 дахин тооцоогүйгээс ажилчдад 47,708.5 мянган төгрөгийн цалинг дутуу тооцож олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.8-д "Ажилтныг ээлжийн хуваарийн дагуу шөнийн цагт ажиллуулбал шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг нэмж олгоно", Алтай-Улиастайн эрчим хүчний систем төрийн өмчит хувьцаат компанийн захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан 2023-2024 оны хамтын гэрээний 3.5-д "тасралтгүй ажиллагаатай аж ахуй нэгж байгууллагуудын ажлын байранд ээлжээр ажилладаг ажилтнуудын шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг дундаж цалин хөлснөөс 1.5 дахин нэмэгдүүлж болно" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу олгосон цалинг төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. Завхан салбар нь ажилчдад томилолтын мөнгө 518.0 мянган төгрөгийг илүү тооцож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2-т "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон томилолтыг төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5. Тосонцэнгэл УЦС ХХК нь толгой компанитай хийх хоорондын тооцоогоор бараа материал сэлбэг хэрэгслийн үнэ 13,410.5 мянган төгрөгийг харилцагч байгууллага руу шилжүүлсэн боловч бараа материалыг нийлүүлээгүй, тооцоо нийлээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-т "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах", 20 дугаар зүйлийн 20.1.2-т "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан төлбөрийг төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

3.2 Албан шаардлага

1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 25 дугаар тогтоолд заасан үндсэн цалинг нэмэгдүүлэх 29.0 хувиас дээш тооцож 22,053.3 мянган төгрөгийн цалинг илүү олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.1-т "гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирсон цалин хөлсийг тогтоосон хугацаанд ажилтанд олгох, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр тогтоогоогүй бол хөдөлмөрийн нормыг үндэслэлтэй тогтоох, аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөж байгаа цалин хөлсний тогтолцоо, журмыг ажилтанд мэдээлэх"; Алтай-Улиастайн эрчим хүчний систем төрийн өмчит хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 25 дугаар тогтоолын....1-д "компанийн 2023 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний цалингийн санд багтаан компанийн ажилтнуудын үндсэн цалинг 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 29 хувь нэмэгдүүлэхийг гүйцэтгэх захирал Б.Цэдэвсүрэнд даалгасугай" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тогтоолын дагуу цалинг нэмэгдүүлж байх албан шаардлага хүргүүлсэн.

2. Гүйцэтгэх захирлууд өөрөө өөртөө тушаал шийдвэр гарган 17,522.7 мянган төгрөгийн сарын үр дүнгийн нэмэгдэл цалин авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2-т "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захирааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тушаал шийдвэрийн дагуу урамшуулал олгож байх албан шаардлага хүргүүлсэн.

3. Завхан салбар, Богдын голын УЦС ХХК нь ажлаас чөлөөлөгдсөн 5 ажилтанд амралтын цалингийн дуусгалын тооцоо хийгээгүй байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийг 83.1-т "Ажил олгогч ажилтны ажлын байрыг хэвээр хадгалах тохиолдолд ажлыг нь түр, хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсон тохиолдолд бүрмөсөн хүлээн авна", 110 дугаар зүйлийн 110.3-т "Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалинг олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралт "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 2.8-т "Ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах, дуусгавар болгох үед ажил олгогч нь ажилтантай ээлжийн амралтын тооцоог дараах байдлаар хийнэ. Үүнд: ажилтанд ажилласан хугацаанд нь ногдох ээлжийн амралтын цалинг олгох; ажилтнаас илүү олгосон ээлжийн амралтын цалингийн суутгалыг хийх" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилтны дуусгалын тооцоог хийх албан шаардлага хүргүүлсэн.

4. Завхан салбар нь өндөр насны тэтгэвэрт гарсан албан хаагчийн эрчим хүчний салбарт ажилласан жилийг буруу тооцож 4,400.0 мянган төгрөгийн тэтгэмж илүү олгосон нь Хамтын гэрээний 5.10-т "Эрчим хүчний салбарт ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмадуудад салбарт ажилласан жил тутамд эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр бодож нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгоно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2-т "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах" гэж заасантай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хамтын гэрээнд заасны дагуу тэтгэмжийг тооцож олгож байх албан шаардлага хүргүүлсэн.

5. Завхан салбар нь гэрээ байгуулалгүйгээр 4,550.7 мянган төгрөгийн тээврийн хөлс, засварын хөлсийг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөлсөөр ажиллах гэрээ байгуулсны үндсэн дээр ажил гүйцэтгүүлж байх албан шаардлага хүргүүлсэн.

6. Завхан салбар, Богдын голын УЦС ХХК нь тайлант онд үндсэн хөрөнгө актлахдаа комисс томилж устгал хийгээгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.3-т "засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгө актлахдаа хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж, холбогдох маягтыг хөтөлж байх албан шаардлага хүргүүлсэн.

7. Толгой компанийн дансанд бүртгэлтэй 2 автомашиныг Тосонцэнгэл УЦС ХХК ашиглаж байгаа боловч балансаас баланст шилжүүлээгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-т "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авто тээврийн хэрэгслийг балансаас баланст шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх албан шаардлага хүргүүлсэн.

8. Толгой компанийн жолоочийн тооцооны хуудсыг тулган баталгаажуулахад Аксент 02-91 ГАО улсын дугаартай авто тээврийн хэрэгслийн спидометрийн заалт 45,330 км-ээр, Nordbenz 17-68 ГАУ/ Ачааны урт машин/ улсын дугаартай авто тээврийн хэрэгслийн спидометрийн заалт 14,997 км-ээр, TLC-land 200 94-49 ГАА улсын дугаартай авто тээврийн хэрэгслийн спидометрийн заалт 18,632.0 км-ээр, бусад 5 авто тээврийн хэрэгслийн спидометрийн заалт 352-6705 км-ээр зөрүүтэй, 1 авто тээврийн хэрэгслийн спидометрийн заалт ажиллахгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.2-т "нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон хууль тогтоомжид харшилсан шийдвэрийг биелүүлэхээс татгалзах"; 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Заалт зөрсөн авто тээврийн хэрэгслүүдийн тооцоог дахин бодож ирүүлэх албан шаардлага хүргүүлсэн.

9. Завхан салбар нь хөрөнгийн тооллого хийсэн боловч анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, нягтлан бодогч тооцоо бодоогүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасантай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тооллого хийж, хөрөнгийн тооцоо бодож байх албан шаардлага хүргүүлсэн.

10. Завхан салбар нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 краныг худалдан борлуулах шийдвэрийг хэрэгжүүлээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2-т "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 369 дүгээр тогтоолын 2.1-т Орон нутгийн өмчийн газрын төлөөллийг оролцуулан үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах, 2.4-т Худалдсан автомашины улсын дугаарыг шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх" гэж заасантай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шийдвэрийн дагуу акталж устгах албан шаардлага хүргүүлсэн.

11. Завхан салбар нь тээвэр шатахууны нярвын тайлан гаргаагүй, жолоочийн замын хуудсанд зарцуулсан шатахууныг бүрэн хөтөлдөггүй, нягтлан бодогч шатахууны тооцоог хангалтгүй бодсон байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай

хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана", 14 дүгээр зүйлийн 14.4.1-т "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шатахууны тооцоо бодож журмын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

12. Богдын голын УЦС ХХК-ийн татварын тодорхойлолтоор авлагын дүн 50,297.4 мянган төгрөгөөр санхүүгийн тайлангаас зөрүүтэй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах"; 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Татварын тодорхойлолтын зөрүүг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

13. Тосонцэнгэл УЦС ХХК нь нийгмийн даатгалын тайлангаар 125.0 мянган төгрөгийн авлагатай боловч тайланд тусгаагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах"; 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалтай тооцоо нийлэх албан шаардлага хүргүүлсэн.

14. Толгой компанийн санхүүгийн тайланд 2015 оноос хойш бүртгэлтэй 33,774.9 мянган төгрөгийн өглөг байгаа бөгөөд эзэн холбогдогч тодорхойгүй, барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эзэн холбогдогч тодорхойгүй өглөгийг барагдуулах албан шаардлага хүргүүлсэн.

15. Тосонцэнгэл УЦС ХХК нь нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд орлогыг дутуу тайлагнаж, 15,077.4 мянган төгрөгийн НӨАТ-ын өглөгтэй байхад тайланд тусгаагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй 15,077.4 мянган төгрөг байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах"; 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланг үнэн зөв гаргах албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тосонцэнгэл УЦС ХХК-ийн конторын барилга 2019 оноос баригдаж эхэлсэн бөгөөд нийт 263,341.5 мянган төгрөгийг гүйцэтгэгчид шилжүүлсэн, барилгын ажлыг гүйцэтгэх гэрээний хугацаа дууссан боловч урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гэрээний хугацаа дууссан барилгын асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэж, холбогдох стандартын дагуу данс бүртгэлд тусгах.

2. Батлагдсан эдийн засгийн зорилтот түвшний биелэлтээр нийт орлого, зардал, алдагдлыг зөрүүтэй тайлагнасан байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "Захирал нь үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түшингийн төлөвлөгөөг мөрдөн ажиллах.

3. Толгой компанийн дансанд бүртгэлтэй 4 автотээврийн хэрэгсэл эвдэрсэн бөгөөд ашиглагдахгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2-т "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах"; 31 дүгээр зүйлийн 31.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ашиглагдахгүй байгаа 4 авто тээврийн хэрэгслийн асуудлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх.

4. Тус компаниудын дансанд бүртгэлтэй 68 газрыг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа талбайн хэмжээ, нэгж талбарын үнэлгээг тус бүрд нь бүртгээгүй бөөн дүнгээр бүртгэсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газрын бүртгэлийг стандартын дагуу бүртгэх.

5. Толгой компаний сум болон авто хариуцсан инженер нь авто тээврийн хэрэгсэл болон сумдад олгосон бараа материал сэлбэг хэрэгслийн шаардах хуудсыг бөөн

дүнгээр бичсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.2-т "нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон хууль тогтоомжид харшилсан шийдвэрийг биелүүлэхээс татгалзах"; 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар ба талгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх"; 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын зарцуулалтын анхан шатны баримтыг журмын дагуу хөтөлж байх.

- Тус компаниуд нь бараа материалын тайланд нэг жилээс дээш жил ашиглагдах бараа материалыг шаардахаар зарцуулсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" " гэж заасантай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын стандартын дагуу акталж устгах байх

- Бүтэц орон тооны тушаалыг өөрчлөн гаргаагүйгээс Алтай-Улиастайн ЭХС, ТӨХК-ийн Завхан дахь салбарт 8 орон тоог илүү ажиллуулсан нь Алтай-Улиастайн Эрчим хүчний систем " ТӨХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 19 дүгээр тогтоолыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Завхан салбарын бүтэц орон тоог шинэчлэн батлах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 12 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК	15	4,223,688.31	-	-	15	4,223,688.31	15	4,223,688.31	-	-	-	-
Дүн	15	4,223,688.31	-	-	15	4,223,688.31	15	4,223,688.31	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

		/мянган төгрөгөөр/	
	Нийт зөрчил	Үүнээс	

Байгууллагын нэр			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК	43	247,697.1	10.0	80,872.7	20	109,475.7	13	57,348.7	43	247,697.1	10.0	80,872.7
Дүн	43	247,697.1	10.0	80,872.7	20	109,475.7	13	57,348.7	43	247,697.1	10.0	80,872.7

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТБОНӨҮГ		1			1			
	НИЙТ		1			1			